



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024.06.21 № 03/10782.
танай _____-ны № _____-г

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигын эсрэг хуулийн 6.1.4-т заасан “төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх” үйл ажиллагаанд хяналт тавих, төсвийн зарцуулалттай холбоотой авлигын эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг, нийслэл, сум дүүргийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх явцад төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоогүйгээс байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын нэгдсэн мэдээлэл зөрүүтэй байгаа байдал тогтоогдов. Тухайлбал,

Аймаг, сумдын Засаг дарга нар 2023 онд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн (<https://eic.mn/finance/>) цахим системд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дутуу төлөвлөж, худал тайлагнасан, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд “тухайн байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн орлогоос 15-85 хувь буюу байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээний доод хязгаараас дээш байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна” гэж заасны дагуу төлөвлөж, зарцуулаагүй, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан нь авлигын гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлж болзошгүй байх тул Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасны дагуу дараах “Зөвлөмж”-ийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаарх хариуг 2024 оны 07 дугаар сарын 25-ны дотор хариу ирүүлнэ үү.

Хавсралт 3 хуудастай.

Хувийг: Аймагын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР




З.БААСАННЯМ

142403010538

Авлигатай тэмцэх газрын
2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
02/... дугаар албан ёсний хавсралт
10782

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ЗӨВЛӨМЖ**



Зөвлөмж 1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль" болон "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-д заасан хувь хэмжээгээр тооцож төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах;

Нөхцөл байдал:

Аймаг нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд "тухайн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 15-85 хувийг тухайн төсвийн жилд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна" гэснийг зөрчсөн, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх "81701" эдийн засгийн ангилалд байгалийн нөөц ашигласны орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, аймгийн Засаг дарга нар "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.4, 3.5, 3.6-д заасан 36 арга хэмжээнээс бусад арга хэмжээ буюу чиг үүрэгт хамааралгүй, хөрөнгө оруулалт, барилга байгууламж, засвар үйлчилгээ, мод тарьсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах зэргээр зарцуулж байгаа нь мөн журмын 3.7-д "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан гэж үзэхээр байна. Тухайлбал,

Орхон аймаг 2023 онд байгаль хамгаалах чиглэлээр 38 төсөл, арга хэмжээний зардалд 4,1 тэрбум төгрөгийн төсвийг баталсан байх ба 26 арга хэмжээнд 1,5 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2023 оны зарцуулалтыг судлан үзэхэд идэвхтэн байгаль хамгаалагчдын урамшуулалд 40,4 сая төгрөг, Засаг даргын 2021 оны А/228 дугаар захирамжаар "Ногоон Эрдэнэт" болзолт уралдаан зохион байгуулж, мод тарьсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагад 69,1 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгожээ.

"Агаарын бохирдол бууруулах мастер төлөвлөгөөний санхүүжилт"-д 33,1 сая төгрөг, Стандартын шаардлага хангасан Эко ариун цэврийн байгууламжийн урамшуулал олгох" ажлын хүрээнд 2021-2023 онд 417,7 сая төгрөгийн төсвийг зарцуулсан байна.

Булган аймаг 2023 онд байгаль хамгаалах чиглэлээр 54 арга хэмжээнд 5,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд төлөвлөсөн арга хэмжээг судлан үзэхэд "Гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн дэд бүтэц, инженерүүдийн шугам сүлжээнд холбох" ажилд 555,1 сая төгрөг, "Эко зуслангийн тохижилт"-ын ажилд 13,5 сая төгрөг, "Байгаль орчинд ээлтэй шахмал түлшний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах" ажилд 24,5 сая төгрөг, "Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах" арга хэмжээнд 218,0 сая төгрөг буюу нийт 811,2 сая төгрөгийг зарцуулсан.

Дархан-Уул аймаг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2023 онд "Тусгай сонирхлын болон спорт аялал жуулчлал"-ын ажилд 2,0 сая төгрөг, "24 цагийн байнгын үйл ажиллагаатай 3 пост байгуулах" ажилд 29,3 сая төгрөг, "Постод ажиллах ажилтан албан хаагчдын ээлжийг солих" ажилд 4,8 сая төгрөг буюу нийт 36,1 сая төгрөгийг зарцуулсан.

Дээрх зарцуулсан үйл ажиллагаанууд нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5.9-д "иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг зохих журмын дагуу худалдан авах, нөхөн сэргээсэн ойг бусад хэлбэрээр урамшуулах", мөн журмын 3.7.-д заасан "Төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 3.5, 3.6-д зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно" гэснийг тус тус зөрчиж байна.

Жич: Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022.08.11-ны өдрийн албан бичигт 2018-2021 оны байдлаар "Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн тухай" хуулийн хэрэгжилт 26-44.7 хувьтай буюу нийт 135.1 тэрбум төгрөгийг аймгууд зориулалтын бусаар зарцуулсан талаар дурдсан.

Зөвлөмж 2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зарцуулах мөнгөн дүнг Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 1.2-т заасны дагуу бүрэн, үнэн зөв тайлангах, зарцуулалтад хяналт тавьж ажиллах;

Нөхцөл байдал:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны "Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ийн 2023 оны хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээг судлан үзэхэд байгаль орчны мэдээллийн [/https://eic.mn/finance/](https://eic.mn/finance/) цахим санд тайлагнасан аймаг, сумдын 2023 оны орлогын төлөвлөгөөт дүн, орлогын гүйцэтгэлийг аймгийн, сумдын тухайн оны баталсан төсөв, гүйцэтгэлтэй харьцуулан үзэхэд үнийн дүн зөрүүтэй, цахим мэдээллийн санд гүйцэтгэлээр олсон орлогыг худал тайлагнасан нийтлэг зөрчил илэрсэн. Мөн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого төлөвлөлт, зарцуулалтын гүйцэтгэлийн тайлан хариуцсан тодорхой албан тушаалтан байхгүй, байгалийн нөөц ашиглалтын байдалд тавих хяналт сул, хангалтгүй байна. Үүнд:

Орхон аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлантай танилцахад байгалийн нөөц ашигласны төлбөрт нийт 26,8 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ. Гэтэл тус аймаг 2023 оны төсвийг батлахдаа байгалийн нөөц ашигласны төлбөрт 21,3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөж, өмнөх оны давсан орлого (2022 оны үлдэгдэл мөнгө) нь 2,1 тэрбум төгрөг буюу нийт 23,4 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн гэж байгаль орчны мэдээллийн (eic.mn)-д цахим санд худал тайлагнасан.

Булган аймаг нь 2023 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болох газрын төлбөрөөс 1,2 тэрбум төгрөг, ойн нөөцөөс 466,1 сая төгрөг, ан амьтны нөөцөөс 47,5 сая төгрөг, ус рашааны нөөцөөс 30,2 тэрбум төгрөг, ургамлын нөөц ашигласны төлбөрөөс 1,5 сая төгрөг, нийт 31,9 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байхад байгаль орчны мэдээллийн (eic.mn) цахим санд 15,9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн гэж худал мэдүүлсэн.

Дархан-Уул аймгийн төсвийн гүйцэтгэлийн 2023 оны тайланг судлан үзэхэд байгалийн нөөц ашигласны төлбөрт 6,4 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байхад

байгаль орчны мэдээллийн (eis.mn) цахим санд 2,1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн гэж мөн адил худал мэдүүлсэн нөхцөл байдал тогтоогдсон.

Зөвлөмж 3. Байгал орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлахдаа төлөвлөлтийг тухайн аймаг, сумдын байгалийн нөөцийн орлогыг бүрдүүлж байгаа эх үүсвэр болох газар, ус, ургамал, ой, ан амьтны болон байгаль орчны судалгаа шинжилгээнд үндэслэн нөхөн сэргээлтийн арга хэмжээг бодитой, үр дүнтэй төлөвлөн хэрэгжүүлэх;

Нөхцөл байдал:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг судалгаа шинжилгээ, байгаль орчны бодит нөхцөл байдалд тулгуурлан боловсруулаагүй, байгалийн нөөцийг тогтоохгүйгээр буруу төлөвлөлт хийснээс байгалийн нөөц хомсдох, төсвийг үр ашиггүй, зориулалтын бусаар зарцуулах үндсэн шалтгаан нөхцөл болж байна. Тухайлбал, "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.4, 3.5, 3.6-д заасан 36 арга хэмжээний дагуу тухайн орлогыг бүрдүүлж байгаа эх үүсвэр болох байгалийн ургамал, ус, ой, ан амьтан, газар болон түүний хэвлийн нөөц"-ийн судалгааг гаргах, ан агнуур, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хөрсний бохирдол, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зүй зохистой төлөвлөх, хэрэгжүүлэхэд зарцуулахгүй, харин хөрөнгө оруулалт, "эко, био ариун цэврийн өрөө байгуулсан аж ахуйн нэгжийг урамшуулах", "агаарын бохирдлыг бууруулах", "аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах", "байгаль орчинд ээлтэй шахмал түлшний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах" зэрэг ажлуудыг төлөвлөж, төсвийг зарцуулсан байна.

Зөвлөмж 4. "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.5.9.-д "иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг зохих журмын дагуу худалдан авах, нөхөн сэргээсэн ойг бусад хэлбэрээр урамшуулах" гэж заасныг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах;

Нөхцөл байдал:

Орхон аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 2023 оны зарцуулалтыг судлан үзэхэд идэвхтэн байгаль хамгаалагчдын урамшуулалд 40,4 сая төгрөг, мод тарьсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагад 69,1 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгожээ. Журамд урамшуулах хэлбэр нь тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг зохих журмаар нөхөн сэргээх, худалдан авахаар байтал дээрх урамшуулсан төсөл, арга хэмжээнүүдэд урамшууллаар олгосон нь уг журмыг баримтлан олгоогүй гэж үзэхээр байна.

Түүнчлэн "идэвхтэн байгаль хамгаалагч, мод тарьсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн аливаа байгууллагыг урамшуулах" асуудал нь авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй байгааг анхаарах шаардлагатай.